1. Тойргийн төвөөс нум хүртэлх хэмжээг сонгоно уу.

   A. радиус B. диаметр C. градус D. хөвч

2. Диаметр нь 70 мм тойрог байгуулахын тулд гортигийн радиусыг хэдэн мм-д тохируулах вэ? Зөв хариуг сонгоно уу.

   A. 20 мм B. 25 мм C. 30 мм D. 35 мм

3. Зохиомжийн тэнцвэр нь дүрсүүдийн хэмжээ, харьцаа, хэлбэр өнгө, байрлал зэргээс хамаардаг. Зохиомжийн ижил бус дүрсийн тэнцвэрийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

4. Параллель зураасыг шугам ашиглан зөв байгуулсан зургийг сонгоно уу.


A.


B.


C.


D.

5. Зураг зүйн стандартын дагуу байгуулсан тойргийг сонгоно уу.


A.



B.



C.



D.

6. Зурагт үзүүлсэн чимэглэлийн зохиомжийг тойргийг хэд тэнцүү хуваах аргаар байгуулсан бэ? Зөв хариуг сонгоно уу.



A. тойргийг 3 болон 6 тэнцүү хуваах арга
B. тойргийг 6 болон 12 тэнцүү хуваах арга
C. тойргийг 4 болон 8 тэнцүү хуваах арга
D. тойргийг 5 болон 12 тэнцүү хуваах арга

7. Тойргийг 6 тэнцүү хуваажхийсэн зохиомжийг сонгоно уу.



A.




B.



C.




D.

8. Сурагчдын бүтээсэн мэндчилгээний загваруудын зохиомжийн зүй тогтлыг зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.




1.




2.




3.

| | | |
|---|---|---|
| a. хэмнэл давтамжтай | b. тэгш хэмтэй | c. тэгш бус хэмтэй |

A. 1-a, 2-b, 3-c
B. 1-c, 2-a, 3-b
C. 1-b, 2-c, 3-a
D. 1-b, 2-a, 3-c

9. Сурагчдын зурсан чимэглэлийн элементүүдийг байгуулсан тойрог тэнцүү хуваах аргатай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.


1.


2.


3.


4.



a.



b.



c.



d.

A. 1-b, 2-c, 3-a, 4-d   B. 1-d, 2-a, 3-c, 4-b   C. 1-a, 2-b, 3-c, 4-d   D. 1-c, 2-d, 3-a, 4-b

10. Модлогуудыг ерөнхийд нь шилмүүст ба навчит мод гэж ангилдаг. Навчит моднуудаас бүрдсэн хариуг сонгоно уу.

A. шинэс, хус, улиас, улиангар, гацуур, жодоо
B. шинэс, нарс, хуш, гацуур, хайлаас, жодоо
C. хар мод, хуш, гацуур, хайлаас, бургас, сөөг
D. хус, улиас, улиангар, хайлаас, бургас, сөөг

11. Модон материал нь физик, механик, технологийн гэсэн шинж чанаруудтай байдаг. Хатуувтар, нягт тогтоцтой, ширхэг судал бараг мэдэгдэхгүй, цайвар өнгөтэй бөгөөд сийлбэртэй эдлэл хийхэд тохиромжтой модыг сонгоно уу.

A. Нарс   B. Улиас   C. Хус   D. Хайлаас

12. Шинэс буюу хар модны онцлог шинж чанарыг тодорхойлсон хариуг сонгоно уу.

A. тод өнгөтэй, гоёмсог хээ зураглалтай, хатуу мод
B. хээ зураглал нь бүдэг, улаавтар өнгөтэй, зөөлөн мод
C. хатуувтар, ширхэг судал мэдэгдэхгүй, цайвар өнгөтэй мод
D. зөөлөн, нягт ширхэгтэй, шаргал цагаан өнгөтэй, хөнгөн мод

13. Металлыг хар ба өнгөт, ховор ба үнэт гэж ангилдаг. Хар металлиудаас бүрдсэн хариуг сонгоно уу.

A. алт, мөнгө, хүрэл   B. төмөр, ширэм, болд
C. зэс, цайр, цагаан тугалга   D. вольфрам, уран, никель

14. Зурагт үзүүлсэн туршилтыг ажиглаад, зөв тайлбарласан хариуг сонгоно уу.



A. Модон материалын физик шинж чанар болох модны өнгө, гялалзалтыг турших байна.
B. Модон материалын физик шинж чанар болох модны нягт, сийрэг байдлыг турших байна.
C. Модон материалын механик шинж чанар болох хатуулаг, гулзайлтыг турших байна.
D. Модон материалын технологийн шинж чанар болох цууралт үүсч байгааг турших байна.

15. Модон материалын физик шинж чанар нь тухайн эдлэлийн хийц, дизайн, харагдах байдалд чухал үүрэгтэй. Зурагт үзүүлсэн модон хайрцаг хийхэд ашигласан модны физик шинж чанарыг сонгоно уу.



A. модны нягт
B. модны чийглэг
C. модны гялалзалт
D. модны хээ зураглал

16. Модон бэлдцийг тайрахад өргөн туузтай, нүх гаргахад нарийн туузтай, углуурга заадал гаргахад углуургын гар хөрөөг хэрэглэдэг. Модон бэлдцэд нүх дугуйрсан хэлбэртэй хэсгүүдийг хөрөөдөхөд тохиромжтой хөрөөг сонгоно уу.



A.



B.



C.



D.

17. Модон эдлэл хийхэд бэлдцийг тодорхой дарааллын дагуу боловсруулдаг. Модон бэлдцийн сумаар заасан элементийг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.



A. догол тал
B. хажуу тал
C. хавтгай тал
D. тайрсан тал

18. Хүмүүс төрөл бүрийн металуудыг ахуйн хэрэглээний, гоёл чимэглэлийн зэрэг олон зориулалтаар ашиглаж иржээ. Үнэт металлыг сонгоно уу.



A.



B.



C.



D.

19. Төмөр утсыг матах, таслах, нугалах аргууд болон багаж хэрэгслүүдийг ажиглаад, хасуураар таслах процессыг харуулсан зургийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

20. Монголчууд модыг гэр ахуйн болон мал аж ахуйн эдлэл хэрэглэл, гоёл чимэглэл, уран сийлбэр зэрэг хийх зүйлдээ тохируулж сонгоод хатааж, халааж тэгшлэх, матах, зорж хэлбэр гаргах ажиллагаа хийдэг. Дараа нь эд ангиудыг наах, углуурга болон малын арьс ширээр үдэж холбох зэрэг уламжлалт технологийг хэрэглэж байсан. Тухайн модоор хийхэд тохиромжтой эдлэлийн жишээг зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

| Модны нэр | Модон эдлэлийн жишээ |
|---|---|
| 1. Хус | a. авдар, ширээ, сандал хаалга, харандааны иш |
| 2. Шинэс | b. гэрийн тавилга, хөгжим, цаас, хиймэл торго гарган авдаг |
| 3. Гацуур | c. хашаа саравч, байшин, модон гүүр, гэрийн мод, үхэр тэрэг |
| 4. Хуш | d. тооно, уурга, хувин, сүх, алхны иш, аяга, зэлийн гадас, тавилга, эмээлийн мод, фанер |

A. 1-d, 2-c, 3-a, 4-b
B. 1-a, 2-b, 3-c, 4-d
C. 1-d, 2-c, 3-b, 4-a
D. 1-b, 2-c, 3-d, 4-a

21. Модон эдлэл хийхэд бэлдцийг технологийн дагуу, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан боловсруулдаг. Банз, брусээр модон эдлэл хийх бэлдэц боловсруулах технологийг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.

1. Хавтгай ба хажуу талыг харуулдаж бааз талуудыг бэлтгэнэ.
2. Банз, брусны овор хэмжээ ба үндсэн элементийг тодорхойлно.
3. Бааз талд өнцөг хэмжигчийг шахагчаар байрлуулан, уртын хэмжээг зурж, хөрөөдөж тайрна.
4. Бааз талаас рейсмусээр өргөний хэмжээг зурж, хэмжээнээс илүү гарсан хэсгийг харуулдаж боловсруулна.

A. 1-2-3-4
B. 1-2-4-3
C. 2-1-4-3
D. 2-1-3-4

22. Төмрийн хүдрийг домен зууханд хайлуулж, ширэм, ширмийг дахин хайлуулж болд гарган авдаг. Болдыг хийцийн, багажийн, нүүрстөрөгчит чанаржуулсан, тусгай найрлагатай гэж ангилдаг. Болдын ангилалд тохирох металлаар хийсэн эд зүйлсийг зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

| Болдын ангилал | Эд зүйлс |
|---|---|
| 1. Хийцийн | a. мэс заслын хутга, хайч, холхивч, хүнсний зориулалттай сав суулга |
| 2. Багажийн | b. төмөр утас, булан төмөр |
| 3. Нүүрстөрөгчит чанаржуулсан | c. гар хөрөө, харуулын ир, төмрийн хөрөө, цүүц, алх, бахь, түлхүүр, төмрийн хайч, хасуур |
| 4. Тусгай найрлагатай | d. төрөл бүрийн техникийн араа, гол, нум зэрэг элэгдэлд тэсвэртэй бат бөх эд ангиуд |

A. 1-d, 2-b, 3-a, 4-c
B. 1-b, 2-c, 3-a, 4-d
C. 1-d, 2-b, 3-c, 4-a
D. 1-b, 2-c, 3-d, 4-a

23. Унадаг дугуй нь олон үе шаттайгаар хөгжсөн тээврийн хэрэгсэл юм. Хүн өөрөө бүрэн хөдөлгөөнд оруулах боломжтой анхны дугуйт тээврийн хэрэгсэл нь дрезина байжээ. Хоёр дугуй нь ижил хэмжээтэй хигээст дугуйнаас бүтсэн загварыг зохион бүтээсэн хүнийг сонгоно уу.

A. 1519 онд Леонардо Да Винчи
B. 1815 онд К.Ф.Дрез
C. 1855 онд Макмиллан
D. 1874 онд Ж.Стэрли

24. Хөдөлгөөн дамжуулах механизмуудаас хэдрэг араат дамжуулгын механизмыг сонгоно уу.


A.


B.


C.


D.

25. Нударган мехнизм нь төвөөсөө тодорхой зайд байрласан эргэлтийн төв бүхий дугуй хэлбэртэй байна. Нударга нь түлхэгчийг аажмаар дээш өргөж, аажим ба огцом доош буулгах хөдөлгөөн үүсгэдэг. Зөвхөн нэг чиглэлд эргүүлэх боломжтой нударган механизмыг сонгоно уу.


A.


B.


C.


D.